

ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг удаа хийж, Төрийн шагналд уламжлах тухай, “Отгонтэнгэр” рашаан сувиллыг менежментийн гэрээгээр эзэмшүүлэх, үр дүнг харгалзан хувьчлах этгээдийг сонгон шалгаруулахтай холбоотой асуудлын талаар, Орон нутгийн хөгжилд Иргэний нийгмийн байгууллагын оруулсан хувь нэмэр цаашид хамтран ажиллах тухай, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээл олголт, түүний хэрэгжилт /2016-2020/ Аялал жуулчлалын гол чиглэл авто замын дагуу түр буудаллах цэг үйлчилгээний цогцолбор байгуулах газрын байршилд санал авах тухай, Дэд зөвлөл шинэчлэн байгуулах тухай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсэг томилж ажиллуулах тухай, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажилд хяналт тавих ажлын хэсэг томилж ажиллуулах тухай, “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ-ыг “Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани” болгож өөрчлөх тухай, Хөрөнгө актлах, Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай, Төрийн шагналд уламжлах тухай Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилох тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гарган биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар “Бяцхан зорчигч” хэсэгчилсэн арга хэмжээ, “Мэдээлье, илрүүлье, зогсооё”- соён гэгээрүүлэх аяныг зохион байгуулах хөтөлбөр төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагуудаас 2021 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний саналыг авч нэгтгэн салбар зөвлөлийн хуралдааны зарыг хүргэсэн.

Хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлын хүрээнд Завхан аймгийн Их-Уул сумын иргэн Д.Эрдэнээд нөхөн олговрын мөнгө болох 80.0 сая төгрөгийг олгосон. Тэлмэн сумын иргэн Г.Бадамд нөхөн олговор 80.0 сая төгрөгийг өгөхөөр гарсан шүүхийн шийдвэр холбогдох материалыг, Алдархаан сумын иргэн Х.Цэрэндашийн гаргасан өргөдөл холбогдох материалыг Монгол улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлсэн.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 дүгээр зарлигаар олон жил үр бүтээлтэй ажиллаж Завхан аймгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмрийг үнэлж Монгол Улсын Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 11 иргэн, Алтан гадас одонгоор 34 иргэн, Хөдөлмөрийн хүндэт медалиар 13 иргэнийг шагнасан.

Иргэдэд шагнал гардуулах үйл ажиллагааг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдөр ёслол төгөлдөр зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Улам-Оргих, аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал нар гардууллаа.

Олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж ажлын өндөр амжилт гаргасан 43 иргэний материалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар, иргэний материалыг 2 дугаар сарын 24-ний хурлаар танилцуулж, “Төрийн шагналд уламжлах тухай” тогтоолыг 2 удаа гаргуулан ажиллалаа.

2020 оны үйл ажиллагааны үр дүнгээр шалгарч, хамт олноо манлайлсан “Шилдэг агентлаг”, албан хаагчдыг шалгаруулан шагналыг гардууллаа.

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал Улиастай сумын бизнес эрхлэгчидтэй уулзаж Завхан аймгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэдээ чиглэсэн онцлох ажлуудын талаар мэдээлэл өгч санал хүсэлтийг нь сонслоо.

Аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Д.Түвшинжаргал аж ахуйн нэгж, албан байгууллагуудыг “Би гүймээр байна” аянд нэгдэхийг уриалж 2 сая төгрөг хандивлалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газраас 24 сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн удирдлагуудад “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хичээл-үйл ажиллагаа эхлүүлэх бэлэн байдлыг хангах нь” сэдэвт цахим сургалт зохион байгууллаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1.Татвар төлөлтийн байдал: Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 137.5 хувийн биелэлттэй, 780.2 сая төгрөгийн орлого оруулснаас цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 39.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 8.4 хувь, авто тээврийн албан татвар 1.3 хувь, татварын бус орлого 4.3 хувь, бусад нэр төрөл 46.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 89.4 хувь буюу 697.7 сая төгрөгийг орон нутгийн орлого, 10.6 хувь буюу 82.5 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр 2020 онд нийт харилцахын үлдэгдэл 19 тэрбум 128.8 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 74.7 мянган иргэний 146.8 тэрбум төгрөг байна. Аймгийн дүнгээр эхний 1 сард нийт олгосон зээлээс 159.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.9 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: 2021 оны 02 дугаар сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны-43, Боловсон хүчний захирамж-2 гарсан байна. Тухайлбал: Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргасан.

Завхан аймгийн стратеги төлөвлөгөөний Хууль ,эрх зүйн бодлогын хүрээн дэх арга хэмжээнүүдийг төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа.

INSURE төслөөс зохион байгуулсан “Бэлчээрийн газрын эрх зүйн орчныг сайжруулах арга зам” сэдэвт оролцогч талуудын зөвлөлдөх цахим уулзалтад 2021.02.18-нд оролцлоо.

Аймгийн Цагдаагийн газраас Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд "Тамхи-Тамхины хяналт" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд утаат тамхи худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж тусгай зөвшөөрлийг шалган шаардлага хүргүүлэн ажиллаа.

Монголынуламжлалт сар шинийн баяр болох гэж байгаатай холбоотойгоор улсын болон орон нутгийн авто замд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх,

аймаг сум хоорондын зорчигч тээвэр, хот хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж Авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор "Сар шинэ-Ачааны автомашин ачаа тээвэрлэлт" хэсэгчилсэн арга хэмжээг 2020 оны 02 дугаар сарын 01-нээс аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл: Аймгийн хэмжээгээр эхний 1 сард 15 гэмт хэрэг гарсаны 1 (6.7%) хувь нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 3 (20.0%) хувь нь бусдын эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 9 (60.0%) хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2 (13.3) хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Эхний 1 сард гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 3 хүн гэмтэж 328.0 сая төгрөгийн хохирол учирсан байна. 1-р сард 953 зөрчил илрүүлж, 24 хүн эрүүлжигдэн, 13 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 97 -оор, баривчлагдсан хүн 13 -аар тус тус өссөн байна.

3.3. Архивын ажлын мэдээлэл: Төрийн архивын баримтыг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд: 174, 213, 252, 128, 114, 194, 208, 227 дүгээр хөмрөг буюу 8 хөмрөг, 8 данс, 93 хадгаламжийн нэгжийн 5830 хуудас баримтыг сканердаж, 8 хөмрөг 8 дансны 93 хадгаламжийн нэгж, 5830 хуудас баримтыг photoshop програмд засварлаж, 7 хөмрөг, 7 дансны 155 хадгаламжийн нэгж, 1393 хуудас баримтаас заалт 1059, хүний нэр 5862 тодорхойлон бичиж цахим холболт хийлээ.

8 хөмрөгийн 404 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж , үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

Давхардсан тоогоор 184 иргэн, 13 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 547 баримт шүүж, 167 хуулбар, 201 лавлагаа, тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүлээ.

Хөмрөг үүсгэгч 202 байгууллагын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ авч хөмрөг үүсгэгчийн мэдээг программд шивж оруулан Архивын тасгийн нэгдсэн тоо бүртгэлийн тайланг гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүлээ.

Үндэсний статистикийн хороо, Архивын ерөнхий газарт албан бичиг хүргүүлж, 2013-2020 оны мал тооллогын бүртгэлийг онлайнгаар Төрийн архивуудад авч, иргэдэд лавлагаа үйлчилгээг хурдан шуурхай хүргүүлэх ажлыг эхлүүлсэн.

Үндэсний дата төвтэй гэрээ байгуулж, и-токен төхөөрөмж авч цахим гарын үсэг ашиглан, Үндэсний төв архив болон бусад аймаг, нийслэлийн архиваас лавлагааг Е-

archives программ ашиглан орон нутагтаа олгож, мөн бусад аймаг орон нутагт илгээж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна.

1 хөмрөг үүсгэгчээс 11 хадгаламжийн нэгж баримтыг хүлээн авч Төрийн архивын сан хөмрөгт баяжилт хийлээ.

3.4.Онцгой байдал: Аймгийн Онцгой комисс коронавируст халдвар (Ковид-19) цар тахал, цаг үеийн нөхцөл байдлын талаар аймгийн Онцгой комиссын шуурхай штабын хурлыг 12 удаа хийж 52 шийдвэр гарган аймгийн Засаг даргын захирамж 5, албан бичиг 11 төлөвлөж холбогдох байгууллага аж ахуй нэгжид хүргүүлэн хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Тус хугацаанд Улаанбаатар хотоос аймгийн харьяал бүхий 406 иргэнийг 02 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд татан авч гэрийн тусгаарлалт, ажиглалтад авсан.

Гэрийн тусгаарлан ажиглалтад 02 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 94 иргэн хянагдаж, түргэвчилсэн оношлуураар нийт өссөн дүнгээр 4331 хүн шинжилгээнд хамрагдсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01 өдрийн А/45 дугаар захирамжаар Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсруулан батлуулсан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний удирдамжийн хүрээнд: Аймгийн Засаг даргын 2021 оны А/35 дугаар захирамжаар “Өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцах” ажлын хэсэг байгуулан удирдамж боловсруулан 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Отгон сумдад ажиллалаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2021 оны анхдугаар хуралдааныг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж зөвлөлийн гишүүдэд 2 цагийн сургалт зохион байгуулж 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж зөвлөмж гаргалаа.

Сумдын Засаг дарга шинээр томилогдсонтой холбогдуулан Онцгой байдлын газраас Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж бусад холбогдох хууль, дүрэм, журам, тушаал, зааврыг хэрэгжүүлэн ажиллах талаар Онцгой байдлын газрын даргын 2021 онь 27/10 дугаар албан бичгээр “Зөвлөмж” боловсруулан хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Энэ сард төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 9 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан хяналт шалгалтыг зохион явууллаа.

Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтаар гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, нормативын дагуу байрлуулаагүй, ажилчдад гамшгаас хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулаагүй, гал унтраагуурууд цэнэг дууссан, авралтын зам гарцын схем зураг, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар, санамжийг байрлуулаагүй, аваарын гэрэлтүүлэг суурилуулаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3, мэдэгдэл 2 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар нийт 13 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Гал түймрийн гаралтын тоог 2020 оны мөн үетэй харьцуулахад 33.3% буурсан үзүүлэлттэй байна.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Шадар сайдын баталсан “Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээ”-ний удирдамжийн дагуу Тэс, Тосонцэнгэл, Улиастай сумдын 6 багийн гэр хорооллын 600 өрх айлаар орж нийт 260 зөрчлийг илрүүлж 90 зөрчлийг арилгуулж, нийт 1900 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, 360 ширхэг санамж бичиг тарааж ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23 өдрийн А/80 захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Ажлын хэсэг” байгуулан Удирдамж төлөвлөгөө боловсруулан батлуулсан.

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар заалтын 7.1, Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэлийн 2.2, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 2.3.2., Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны

төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж сумын гамшгийн эрсдэлийн түвшинг анхан шатанд тодорхойллоо.

Үнэлгээнд Улиастай сумын 6 багийн төлөөлөл оролцож олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх индикаторын аргачлалаар ажилласан. Үнэлгээний дүнд Улиастай сум дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.

Мөн баг тус гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг эрсдэлийн түвшин дунд болон өндөр эрсдэлтэй гамшиг бүр дээр төлөвлөсөн.

Улиастай сум дахь өндөр үнэлэгдсэн аюулын төрөл:

№	Аюулт үзэгдлийн төрөл	Аюулын зэрэг	Аюулын зэргийн оноо
1	Объектын гал түймэр	I	76
2	Үер	II	74
3	Газар хөдлөлт	III	73

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: Теле болон цахим хэлбэрээр зохион байгуулсан хичээл, сургалтын үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, агуулгын болон хөгжлийн хоцрогдлыг богино хугацаанд арилгах, сургалтын хөтөлбөрийн бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад орон нутгийн онцгой комиссын зөвшөөрлийн үндсэн дээр халдвар хамгааллын дэглэм баримтлан сургуулийн орчинд давтлага зохион байгуулж ерөнхий боловсролын 23 сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалт өгөх суралцагчдын мэдээллийг 10 судлагдахуун бүрээр гаргалаа. Нийт 860 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдах судалгаа гарсан.

Элсэлтийн ерөнхий шалгалтын давтлага танхимаар зохион байгуулахад мөрдөх түр журам боловсруулан 23 сургууль дээр танхимын давтлага зохион байгуулж байна.



Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд цахим хэлбэрээр зохион байгуулж дараах чиглэлээр зохион байгуулж байна.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж байгаа 7 хоногийн 2, 3, 4 дэх өдрүүдэд болдог “Мэргэжлийн бүлэг”-ийн хэлэлцүүлэгт судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд оролцож, саналаа солилцож ажиллахаас гадна судлагдахууны багш нарын бүлэг үүсгэн хэлэлцүүлэг хийн, саналаа солилцон үйл ажиллагааны болон агуулгын төлөвлөгөөг анги, бүлэг бүрээр гарган ажиллаж байна. Энэ нь бусадтай туршлагаа худаалцах түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Энэ 7 хоногт Сургуулийн өмнөх боловсролын багш нарын дунд “Монгол хэлний зөв бичих зүй” сургалтыг TEAMS програм ашиглан зохион байгуулж байна. Сургалтын явцад эцэг эхчүүд хүүхдүүдэд зориулсан “Ковид-19” өөс урьдчилан сэргийлэх зөвлөмж

санамжууд боловсруулан цэцэрлэгийн бүлгүүдийн группүүдээр байршууллаа. Сургалтад 114 багш оролцож байна.

2021 оны 02 дугаар сарын 18- ны өдөр Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан “СӨБ-ын сургалт үйл ажиллагааны чиглэл”ийг орон нутагт хэрэгжүүлэх арга зүй сургалтыг Увс, Дархан аймгийн багш нартай хамтран зохион байгууллаа.

2021 оны 02 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах нь” цахим сургалтыг ерөнхий боловсролын 29 сургуулийн бага боловсролын багш, нийгмийн ажилтан нийт 58 иргэнд зохион байгууллаа.

Суралцагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орныхоо түүх соёл, ёс заншил, өв уламжлалаараа бахархдаг иргэн болгох зорилгоор аймгийн Засаг даргын ивээл дор сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн суралцагчдын дунд “МИНИЙ ЭХ ОРОН-МОНГОЛ” цахим уралдааны удирдамжийг боловсруулан удирдлагуудад хүргэлээ.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудаас ирсэн бүтээлүүдийг хүлээн авч байна.

2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Улиастай сумын орлогч дарга, цагдаагийн газартай хамтран Улиастай сумын 5 сургуулийн удирдлагад “Бяцхан зорчигч” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөлтийг танилцууллаа. Мөн хүүхдийг зам тээврээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБ-ын ЖЦС-ийг урагшаа гарч буй хаалгаа баруун тийш болгох, ЕБ-ын Дэвшил сургуулийг хайсан хаалтаа уртасгах, ЕБ-ын III сургуулийг багш ажилчдын машины зогсоолыг баруун талдаа хийх, сургуулийн урд талын шороог тэгшлэх чиглэл өглөө.

Ерөнхий боловсролын 29 сургуулийн бага боловсролын багш нарт бага боловсролын суралцагчдыг хичээлийн агуулга, теле хичээлээр сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг оношилж ялгаатай суралцагчдад өмнөх улирлын агуулгын хоцрогдлыг арилгах, хичээл сургалтыг зохион байгуулах эрэлт хэрэгцээний дагуу

а. Багш суралцагчдыг оношлох

б. Багш сургалтын өмнө оношилгоо хийх

в. Суралцагчийн мэдлэг, чадварыг оношлох дүн шинжилгээ хийх

г. Сургуулийн удирдлага багш нарын хамтын ажиллагааны чиглэлээр ажлаа төлөвлөж ажиллах чиглэл өгч ажиллалаа.

2021 оны 02 дугаар сарын 01-28-ны өдрүүдэд бага боловсролын багш нарын бичих чадвар, найруулан бичих чадварыг нэмэгдүүлэх зорилгоор

А. Миний эх орон

Б. Надад тохиолдсон баярт явдал

В. Би ирээдүйд

Г. Энэрэл сэдвээр тус тус 120-150 үгтэй зохион бичлэг бичүүлэн, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Бага боловсролын багш нарын өгүүлбэртэй бодлого бодох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 7 хоног бүр Д.Бүндэнгийн сургалтын материалаас 40 бодлого бодуулан, бодох аргыг тайлбарлан онолын мэдлэгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

“Ээжээ тандаа баярлалаа” гар зураг, захидлын уралдаанд ирсэн 60 гаруй бүтээлүүдийг уншиж шалгарууллаа.

ХБХЭМБНХ-ын салбар комиссын 2 удаагийн хуралд оролцож нийт 20 хүүхдийн өвчний оноштой танилцаж 17 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлон боловсролын үйлчилгээнд хамрагдах, анхаарах асуудлыг бичиж зөвлөгөө өгч ажиллалаа.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: Аймгийн хэмжээнд эхний 1 сард 102 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 103 болж, өмнөх оноос амаржсан эх 10 (8.9%)-аар, амьд төрсөн хүүхэд 9 (8.0%)-өөр буурсан байна. Нялхсын эндэгдэл 3 болж, өмнөх оноос 1 (50.0%)-аар, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 болж, өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 23 болж, өмнөх оноос 29 (55.8%)-өөр буурсан байна. Эхний 1 сард 1.6 мянган өвчтөнийг 10395 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 27.4 мянган хүнд амбулаториор үйлчилж, 113 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авчээ.

Аймгийн ЗДТГ, БСУГ-тай хамтран боловсролын байгууллагуудын удирдлагуудад “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хичээлийн үйл ажиллагаа эхлүүлэх бэлэн байдлыг хангах нь” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 6 төрлийн 306 ширхэг зурагт хуудсыг тараасан байна.

Монгол Улсын шадар сайд, Онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14- ны өдрийн "Коронавируст халдар (COVID-19)-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам", Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн А/29 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж, 2021 оны 2-р сарын 26-ний байдлаар аймгийн хэмжээнд нийт 1252 иргэн ирсэнийг бүртгэлжүүлэн, тандалт судалгааг хийж, голомт бүхий бүс нутгаас ирсэн 859 иргэнийг гэрийн тусгаарлалтад авч, Цагдаагийн газар, Тагнуулын газар, Харъяа эрүүл мэндийн байгууллага болон Төрийн албан хаагч нартай хамтран хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон, сумдын Онцгой комиссын дарга нарт Дархлаажуулалт байнгын цэгийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулан, Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалт зохион байгуулах салбар хоорондын төлөвлөгөө, Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалт зохион байгуулах төлөвлөгөөг тус тус гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумдын эрүүл мэндийн байгууллагуудын 2021 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисын гэрээг 10 эм ханган нийлүүлэх байгууллагуудтай байгуулан, татан авалт хийж байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж буй “Чадварлаг эмч” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр , төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын дунд 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна.

Нийгмийн даатгал, халамж

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 1 сард 12.0 мянган хүнд 4.6 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 1.1 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 33.7 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 7.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 26.2 хувиар тасарч, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 24.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 4354.0 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 242.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 4.2 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 37.9 сая төгрөг тус тус зарцуулж нийт 4638.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн сангийн үйл ажиллагааны эхний хагас жилийн мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1506 хүнд 467.9 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 8522 хүнд 220.2 сая төгрөг нийт 10028 хүнд 688.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 683 болж, өнгөрсөн оны мөн үеэс 17.4 хувиар буюу 101 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 338 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 49.5 хувийг эзэлж байна.

2021 оны 1 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 5 жилийн дунджаас 31.9 хувиар буюу 552 хүнээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 13.0 хувь нь 15-24 нас, 27.7 хувь нь 25-34 нас, 28.6 хувь нь 35-44 нас, 23.1 хувь нь 45-54 нас, 5.3 хувь нь 55-59 нас, 2.3 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 0.8 хувь нь боловсролгүй, 1.9 хувь нь бага, 6.7 хувь нь суурь, 58.4 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.6 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: 2-р сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр 8.3 мянган том мал зүй бусаар хорогдоод байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувь буюу 3.1 мянган толгойгоор буурсан байна. Нийт хорогдолд хээлтэгчийн хорогдол 4.4 хувь, бог малын хорогдол 84.8 хувь, бод малын хорогдол 15.2 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн газар тариалангийн 2021 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө сумдаар гаргаж батлуулан аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа хүргүүлсэн. Газар тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөөр үр тариа 1862 га, малын тэжээл 2100 га, төмс 200 га, хүнсний ногоо 157 га-д тариалалт хийж үр тариа 1688 тн, ногоон тэжээл 4830 тн, төмс 2106 тн, хүнсний ногоо 1746 тн-ыг хураан авна.

Завхан аймгийн 24 сумын хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэгчдийн зоорь, агуулах дахь нөөцийн мэдээнд үндэслэн аймгийн жишсэн дундаж хүн амын хүнсний хангамжийн түвшинг тооцоолж ХХААХҮЯ-д 7 хоногт 2 удаа, аймгийн ЗДТГ-т тогтмол хүргүүлж байна.

Аймгийн хэмжээнд хадгалж, нөөцөлсөн махны судалгааг гаргаж ХХААХҮЯ-д хүргүүлсэн. Нийт 380.3 тн мах хадгалж нөөцөлсөн байна.

2021 оны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай 1900 тун Дотрын халдварт хордлогын вакцин, 250.0 тун Шөвөг ярын вакциныг Биокомбинат УТҮГазраас татан авсан. Малын халдварт Галзуу өвчин /чоно/, Шөвөг яр өвчнөөр тус тус 1 мал өвчилж хорогдсон байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 12 дугаар 18-ны өдрийн 06 дугаар албан даалгавар буюу "Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ

авах, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх" чиглэл ирсэнтэй холбогдуулан Завхан аймгийн МХГ, МЭГ, БОАЖГ, Хомын талын тахь ТББ хамтран аймгийн Засаг даргын орлогчоор төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу сум орон нутаг өөрийн хөрөнгөөр зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээг цагийн байдлыг харгалзан авч байгаа бөгөөд одоогийн байдлаар Идэр суманд 10 боодол өвс 2 уут хужир, Түдэвтэй суманд 22 боодол өвс 2 уут хужир, Сонгино суманд 50 боодол өвс 20 уут хужир, Алдархаан суманд 15 боодол өвс, 3 уут хужир, Цагаанхайрхан суманд 26 боодол өвс, 2 уут хужир, Яруу 8 боодол өвс 2 уут хужир, Шилүүстэй суманд 58 боодол өвс, Отгон суманд 5 боодол өвс 2 уут хужир байршуулсан байна. Одоогийн байдлаар Аймгийн хэмжээнд нийтдээ 28 цэгт 275 боодол өвс, 58 уут хужир буюу 2,9 тн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авсан байна.

УАБАЦБТөлөвлөөний багийн гишүүд, ус хангамжийн зураглал, Ус хангамжийн эрсдлийн үнэлгээ, бууруулах арга зам, Эрсдэл бууруулах чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, Ундны усны шинжилгээ дүгнэлт, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, Тойм үнэлгээ, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө зэрэгтэй танилцаж, сайжруулах зөвөлгөө өгч ажиллах ажлын хүрээнд Идэр, Тэлмэн сумдад ажиллалаа.

Тус сумдын УАБАЦБТөлөвлөөний багийн гишүүдэд болон иргэдэд төлөвлөөгөөний хэрэгжилт хэрхэн явагдаж байна. Цаашид хийгдэх ажлыг нэмж тусгах талаар ярилцаж, ус хангамжийн эх үүсвэр дээр газар дээр нь очиж танилцаж зөрчил дутагдалуудыг эрэмбэлж цаашид шат дараатайгаар сайжруулах талаах төлөвлөгөөнд нэмж тусгахаар болсон юм.

Завхан аймгийн сумууд ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй болсоноор учирч болох эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрэлдэж байна. Мөн сумуудад хуванцар савны хор хөнөөлийн талаар, хэрхэн аюулгүй саванд усыг нөөцөлж унданд хэрэглэж хэвших талаар сургалтыг хийлээ.

6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 1 сарын байдлаар оны үнээр 1 тэрбум 647.9 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 4.8 хувиар буюу 76.1 сая төгрөгөөр өсч, нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 3 тэр бум 363.2 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 284.7 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 44.8 хувийг, хүнсний үйлдвэрлэл 14.6 хувь, хувцас үйлдвэрлэл 11.7 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 0.2 хувь, арьс ширэн эдлэл

үйлдвэрлэл 1.5 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.3 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 1.6 хувь, бусад үйлдвэрлэл 25.3 хувийг тус тус эзэлж байна.

6.3. Дэд бүтцийн чиглэлээр: Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан хаягжуулалтын журам, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 15 дугаар тушаалаар батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Энэ ажлын хүрээнд 2013-2017 онуудад хийгдсэн хаягийн зураг, хаягийн мэдээллийн санг шинэчлэгдсэн журамд нийцүүлэн бүрдүүлэх шаардлагатай байгаа ба уг ажлын хүрээн хаягийн мэдээллийн систем бий болсноор төрийн болон бусад байгууллага, иргэдийг байршилд суурилсан хаягийн баталгаажсан мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хүргэх чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд цаашид хаягийн мэдээллийг замчлах системд оруулан ашиглаж яаралтай тусламж, онцгой байдал, аюул ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зэрэг үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үнэн зөв мэдээллээр хангах тогтолцоо бүрдэх юм.

Хаягийн зураг, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2017 онд хүлээн авснаас хойш сумдууд хаягийн зураг, мэдээллийн сангийн шинэчлэлт дутуу хийгдэх, тусгай барилга, байгууламжууд үсгэн тоон тэмдэглэгээгээр хаяглагдаагүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдаагүй гудамжны нэр, дугаарыг хаягийн зурагт оруулсан, орон нутгийн сонгуулийн дараа гудамжны нэрийг өөрчлөх тохиолдол гарсан бөгөөд зохих өөрчлөлтийг тухай бүр хаягийн мэдээллийн санд оруулахгүй байх зэрэг нийтлэг зөрчил их байгаатай холбогдуулан хаягийн мэдээлэл шалгах, засварлах ажлын төлөвлөгөөний дагуу удирдамж гарган **24** сумын хаягийн мэдээллийн санг бүрэн засварлаж хийж дуусгалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны 1-р сарын 21 өдрийн А/20 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн прокурорын газрын барилгад улсын комисс, Арц суурийн боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын байр хүртэл 48 км шилэн кабельд холбох ажлыг ашиглалтанд оруулах комиссыг 2021 оны 2-р сарын 22 өдрийн А/75 тоот захирамж гаргуулан ажилласан.

“Баян-Айраг эксплорэйшн” ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн шугам засвар шинэчлэлтийн ажилд хяналт гүйцэтгэж ажиллалаа.

Шугам сүлжээг шинэчлэх, засварлах ажлын зургийг “Шигота” ХХК-д хийлгүүлж “Говийн нар констракшн” ХХК угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Баяжуулах үйлдвэрийн уусмал дамжуулах шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлын явцад хяналт хийхэд ажлын зураг төсөв баталгаажуулаагүй,

ажлын нарийвчилсан зураг байхгүйн улмаас шугамын уналт, дулаалгын ажил тодорхойгүй, ил далд ажлын акт бичиг баримт үйлдээгүй, баталгаажуулаагүй, шугамын угсралтын ажил гүйцэтгэх явцад ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөөгүй, ажлын тоо хэмжээ байхгүй зэрэг зөрчил дутагдалтай байна. Үүссэн зөрчил дутагдлын талаар ажлын журналд тэмдэглэл хөтлөн үүрэг даалгавар өгч ажилласан. Гадна шугамын дулаалга хийх эрдэс хөвөн дулаалгыг ажлын зураг гарсаны дараа технологийн дагуу гүйцэтгэх зэрэг үүрэг даалгавар өгсөн.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР